



ЭМ ХАНГАН НИЙЛҮҮЛЭХ БАЙГУУЛЛАГУУДАД

**УЛСЫН ХОЁРДУГААР
ТӨВ ЭМНЭЛЭГ**

13381 Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг,
Энхтайваны өргөн чөлөө 49, Утас/Факс: (976) 7015 0308
И-мэйл: info@ssch.gov.mn, Вэб: www.ssch.gov.mn

2023 08.31 № 9/737
танай _____-ны № _____-т
Тендерийн урилга хүргүүлэх тухай

Тендер шалгаруулалтын нэр: Эм, эмнэлгийн хэрэгсэл, оношлуур худалдан авах
Тендер шалгаруулалтын дугаар: УХТЭ/202302001

Улсын хоёрдугаар төв эмнэлэг нь тендерийн баримт бичигт заасан шалгуур үзүүлэлт, шаардлагыг хангасан хуулийн этгээдийг эмнэлгийн "Эм, эмнэлгийн хэрэгсэл, оношлуур худалдан авах" нийлүүлэх тендерт оролцохыг урьж байна. (Тоо хэмжээ, техникийн тодорхойлолт, нийлүүлэлтийн хуваарийг хавсаргав)

Тус эмнэлгийн Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 34 дүгээр зүйлийн 34 дүгээр зүйлийн 34.1.1 дэх заалтыг үндэслэн шууд гэрээ байгуулах аргаар зарлаж буй тендерт оролцохыг урьж байна.

Сонирхогч этгээдийн ирүүлсэн тендерийг Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 34 дүгээр зүйлийн 34.2-д "Хуулийн 14-16 дугаар зүйлд шаардлагыг хангасан, тухайн бараа, ажил, үйлчилгээг гүйцэтгэх чадавхитай нэг, эсхүл түүнээс дээш тооны этгээдтэй хэлэлцээ хийж, техникийн тодорхойлолт болон бусад нөхцөл, шаардлагыг хамгийн сайн хангасан этгээдтэй энэ хуульд заасны дагуу гэрээ байгуулах" гэж заасныг баримтлан сонгон шалгаруулна.

Хэрэв тус эмнэлгийн зарласан тендерт оролцохыг хүсвэл доорх баримт бичгийг бэлтгэн ирүүлнэ үү.

1. Улсын бүртгэлийн гэрчилгээний эхээс хийсэн хуулбар хувь;
2. Шүүхийн тусгай архивын лавлагаа, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын тодорхойлолт;
3. Монгол Улсын хуулийн дагуу Нийгмийн даатгал, Татварын хураамж, төлбөрөө тухайн тендер нээсэн өдрийн байдлаар бүрэн төлсөн, өр төлбөргүй байх шаардлагатай ба нотлох баримт бичиг;
4. Эм, эмнэлгийн хэрэгсэл ханган нийлүүлэх тусгай зөвшөөрлийн гэрчилгээний эхээс хийсэн хуулбар хувь;
5. Ижил төстэй бараа нийлүүлсэн туршлагыг нотлох гэрээний мэдээлэл: Шаардлагатай. Маят №5, 6, 7-ын дагуу ирүүлнэ. (Хавсралт 1);
6. Техникийн тодорхойлолтын харьцуулалт хийж ирүүлэх. (Техникийн тодорхойлолтыг үндсэн дээж, каталогтой харьцуулах бөгөөд зөрсөн тохиолдолд татгалзах үндэслэл болно);
7. Эм, эмнэлгийн хэрэгслийн заасан багцуудад (багцын нэрний ард "дээж ирүүлэх" гэсэн бол багцад байх бүх эм, эмнэлгийн хэрэгсэл нэг бүрд дээж ирүүлэх) тендер нээгдэхээс өмнө буюу 2023 оны 09-р сарын 08-ны өдрийн 11:00 цагаас өмнө загвар дээжийг ирүүлэх (каталогоор ирүүлсэн загварыг тооцохгүй);

Тендерийг 2023 оны 09 дүгээр сарын 08-ны өдрийн 11 цаг 00 минутаас өмнө тендерийн баримт бичигт заасан хэлбэрээр ирүүлэх ба тендерийн нээлтийг 2023 оны 09 дүгээр сарын 08-ны өдрийн 11 цаг 10 минут-д зохион байгуулна.

Сонирхсон этгээд тендерийн баримт бичигтэй холбоотой тодруулга, нэмэлт мэдээлэл авах хүсэлтийг доорх хаягаар хүргүүлж болно.

Улсын хоёрдугаар төв эмнэлгийн Эм зүйн алба

Утас: 70150231, (dep.pharmacy@ssch.gov.mn)

ЕРӨНХИЙ ЗАХИРАЛ



Маягт 5 Ижил төстэй бараа нийлүүлсэн гэрээний мэдээлэл

Гэрээний нэр	Захиалагчийн нэр, хаяг, холбоо барих утас	Төсөвт өртөг	Хугацаа /эхэлсэн, дууссан/

Маягт 6 Хэрэгжүүлж байгаа, хэрэгжүүлэхээр эрх авсан гэрээний мэдээлэл

Гэрээний нэр	Захиалагчийн нэр, хаяг, холбоо барих утас	Төсөвт өртөг	Гэрээ эхэлсэн хугацаа	Хүлээгдэж буй гүйцэтгэлийн хувь, мөнгөн дүнгээр	Дуусах хугацаа

Маягт 7 Ижил төстэй гэрээний дэлгэрэнгүй мэдээлэл

Тендерт оролцогчийн нэр: [түншлэлийн гишүүн тус бүр бүрэн дуусгавар болсон гэрээ тус бүрээр бөглөнө].

1.	Захиалагчийн нэр
2.	Гэрээний нэр
3.	Гэрээний дугаар
4.	Гэрээ байгуулсан огноо
5.	Гэрээ дуусгавар болсон огноо
6.	Гэрээний дүн
7.	Гэрээ гүйцэтгэсэн хаяг, байршил